



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.31 № 01/608
танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БҮРЭНТОГТОХ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА Б.БАТЦОГТ ТАНАА**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.



МОНГОЛ УЛАСЫН
ХАМГААГАХ АЖ АХУЙН
ТӨСӨВ

Төрийн захирлын
тушаал
№ 100
2024.07.31

Хүндэтгэн
Төрийн захирал

Төрийн захирлын
тушаал

№ 100

2024.07.31

Хүндэтгэн

Төрийн захирал

Төрийн захирлын

тушаал

№ 100

2024.07.31

Хүндэтгэн

Төрийн захирал

Төрийн захирлын

тушаал



№ 100

2024.07.31

Хүндэтгэн

Төрийн захирал

Боловсруулсан:
Хянасан:
Хувь: 3
Огноо: 2024.07.31


J. Nurbazar

D. Tsingalser

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Монгол Ардын намын хорооны Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (.᠖. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Монгол Ардын намын хороонд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт .᠖. хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



**МОНГОЛ
АРДЫН НАМ**

**ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО
БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ**

2024-2028 ОН

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН БҮРЭНТОГТОХ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ХӨВСГӨЛ АЙМАГ
2024 он**



АГУУЛГА

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРГЭХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1 ЭРҮҮЛ МЭНД
- 1.2 БОЛОВСРОЛ
- 1.3 ХҮН АМ, НИЙГМИЙН БҮЛЭГТ ЧИГЛЭСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО
- 1.4 СОЁЛ

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ТОГТВОРТОЙ ХАНГАХ БОДЛОГО

- 2.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ШИНЭ АЖЛЫН БАЙР, БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН, НЭМҮҮ ӨРТӨГ ШИНГЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭР
- 2.2 ЭРЧИМ ХҮЧ, ЗАМ ТЭЭВЭР, ЛОЖИСТИК
- 2.3 ДӨРВӨН УЛИРЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ
- 2.4 ЭРҮҮЛ ХҮНС
- 2.5 ХӨДӨӨ АЖ АХУЙ, ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН
- 2.6 БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ДЭВШИЛТЭТ УУЛ УУРХАЙ

ГУРАВ. ШУДАРГА ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ


- 3.1 ХҮНИЙ ЭРХ
- 3.2 ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО БА НИЙГМИЙН БАТАЛГАА
- 3.3 E MONGOLIA ШИНЭЧЛЭЛ, ЦАХИМ ЗАСАГЛАЛ
- 4.4 ИРГЭДЭД ОЙР ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ДӨРӨВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

- 4.1 УЛАМЖЛАЛТ НҮҮДЛИЙН АЖ АХУЙ БА СОРИЛТ БЭРХШЭЭЛ
- 4.2 НОГООН ЭДИЙН ЗАСАГ

ТАВ. ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1 ХОЙТ БҮСИЙН ХӨГЖИЛ
- 5.2 БҮРЭНТОГТОХ СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ


Сумын МАН-ын хорооны Тэргүүлэгчдийн
2024 оны 06-р сарын 21-өдрийн 09-р тогтоолоор батлав.
Мерийн хөтөлбөрт оруулах санал

Үндэслэл:

Монгол улсын Алсын хараа-2050 хөтөлбөр, Хөгжсөн Хөвсгөл 2030 хөтөлбөр, МАН-ын 2024 оны сонгуулийн мерийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт арга хэмжээг сум орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, сумын хэмжээнд ажлын шинэ байр гаргах, өрх, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, төрийн байгууллагын зүгээс иргэдэд үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэл хүнд сурталгүй хүргэхэд чиглэнэ.

Уриа:

Та итгэ-Бид зүтгэнэ

ЗОРИЛГО:

Төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмж, хамрах хүрээг өргөтгөх, өрх иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, улс, аймаг, сумын төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах, төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой зөв зүйлд зарцуулж, шинэ ажлын байр бий болгож, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, баялаг бүтээж буй аж ахуйн нэгж, хоршоо, иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагааг бүх талаар дэмжихэд сумын МАН-ын хорооны мерийн хөтөлбөрийн гол зорилго чиглэгдэнэ.

Нэг. Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх, хүний хөгжлийн бодлого

1.1 Эрүүл мэнд:


1.1.1 "Элэг бүтэн Монгол", хүүхдийн "Эрүүл шүд", "Хавдаргүй Монгол" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг сумын төв, хөдөөгийн багт сайтар зохион байгуулж, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд иргэдийг бүрэн хамруулна.

1.1.2 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаа, дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулна.

1.1.3 Эрүүл мэндийн төвд "Иргэдэд үйлчлэх төв" нээж ажиллуулах, энэ төв нь хөдөөгийн иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, цагийн тариа хийх, ганцаарчилсан сургалт явуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

1.1.4 Сумын эрүүл мэндийн төвийн эмчлүүлэгчдийн 1-өрөөг "Ахмадын өрөө" болгож засварлаж тохижуулна.





1.1.5 Сумын хүн эмнэлэгийн хуучин байрыг засварлаж, зарим хэсгийг ажилчдын орон сууцны зориулалтаар ашиглах, үлдсэн хэсгийг нийгмийн эрүүл мэндийн сургалт, биеийн тамир чийрэгжүүлэлт, ардын эмнэлгийн эмчилгээ, сувилгаа, шүдний эмчилгээ явуулах чиглэлээр ашиглана.

1.1.6 Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож хэвшүүлэхэд соёл спотын цогцолбор, ЭМТ-ийн чийрэгжүүлэх өрөө , ахмад настан, ХБИ-дэд үйлчлэх төвийн байр танхимыг өргөнөөр ашиглаж, иргэдийн биеийн тамираар хичээллэх хүсэл сонирхолыг нэмэгдүүлэнэ.

1.2 Боловсрол:

1.2.1 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж, бүлэг дүүргэлтийн стандартын түвшинд хүргэх зорилт тавьж ажиллана.

1.2.2 Бага дунд боловсролын чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, үндэсний өв уламжлал, биет болон биет бус соёлыг түгээн дэлгэрүүлэх, зан заншил, эх оронч сэтгэлгээг тусган хэрэгжүүлэх, хүүхдийн өөрийнх нь авъяаст тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургахад анхаарна.

1.2.3 Боловсролын тухай хуульд англи хэлийг үндсэн гадаад хэлээр тодорхойлсон тул хичээлийн хөтөлбөрийн дагуу хүүхэд бүрт англи хэлийг суралцах тэгш боломжийг бүрдүүлж өгнө.

1.2.4 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.2.5 Байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбай байгуулна.

1.2.6 Сургууль, цэцэрлэгийн орчныг бүрэн камержүүлж, хүүхдийн аюулгүй таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

1.2.7 Цэцэрлэгийн хүүхдийн хоол, ЕБС-ийн үдийн цайны стандартыг шинэчилж, орц, найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү, сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

1.3 Хүн ам, нийгмийн бүлэгт чиглэсэн хөгжлийн бодлого:

1.3.1 Бүрэнхаан багт халуун усны барилга бариулахыг дэмжинэ.

1.3.2 Бүрэнхаан багийн төв Баян голд модон гүүр барихыг дэмжинэ.

1.3.3 Их-Уул, Сангийн далай багуудад үүрэн холбооны 4G сүлжээ шинээр суурьлуулах асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

1.3.4 Сангийн далай багийн төвийг Хөх цавын аманд нүүлгэн шилжүүлж суурьшуулах, багт төрийн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх байр танхим шинээр байгуулж иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулна.

1.3.5 Бүрэнхаан багт тоглоомын задгай талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулахыг дэмжинэ.

1.3.6 Зарим багт орчин үеийн мал угаах тоног төхөөрөмж суурьлуулж, малчид, иргэдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх ажлыг дэмжинэ.

1.3.7 Уурын зууханд өргөтгөл шинэчлэл засвар хийж одоо эзэмшин ажиллуулж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс сумын ЗДТГ-т хүлээн авч ОНӨҮГ-ын статусаар ажиллуулах, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн барилгыг улсын төсвийн хөрөнгөөр байгуулах, сумын төвийн боломжтой гудамж, хорооллын айл өрхүүдийг халуун, хүйтэн устай дулаан халаалтанд холбох ажлыг шат дараалалтай авч хэрэгжүүлэх

1.3.8 Зарим багт мал ноослох агрегат, тоног төхөөрөмжийг ОНХС-ийн болон хоршоодын хөрөнгө санхүүгийн дэмжлэгтэйгээр худалдан авч ашиглана

1.3.9 Сумын төвд малчдын сүү, цагаан идээ, ахмад настануудын хийсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан борлуулах дэлгүүр барьж ашиглалтад оруулахыг дэмжинэ.

1.3.10 Ахмад настан, ХБИ-ийн байрыг түшиглэн тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан соёл, урлагийн арга хэмжээ, нийтийн биеийн тамир, биллъярд тоглох зэрэг арга хэмжээ явуулах нээлттэй талбай байгуулахыг дэмжин хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

1.3.11 УИХ-аас гэр бүл хүүхэд залуучуудын талаар баримтлах хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, гэр бүлийн хүчирхийлэлд амьдардаг болон хагас, бүтэн өнчин хүүхдийн эцэг, эх асран хамгаалагч нарыг нийгмийн ажилтнуудын анхаарлын төвд байлгаж хяналтыг эрс сайжруулна.

1.4 Соёл:

1.4.1 Соёлын төвийн музейн үзмэрийг Хотогойд ястаны ёс заншил, биет болон биет бус өв, эд өлгийн зүйлээр баяжуулна.

1.4.2 Соёлын төвд тус сумаас төрсөн улсын хэмжээний хөдөлмөрийн сайчууд, дэлхий, олон улсын тавцанд нэр алдраа цуурайтуулсан хүмүүс, төр нийгмийн зүтгэлтэн, алдар гавъяатнуудын намтар түүхийг харуулсан "Сумын алдартнууд"-ын танхим шинээр байгуулна.

1.4.3 Соёлын төвд соёл урлагийн орчин үеийн шинэлэг хэлбэрийн арга хэмжээг иргэдэд сурталчлах зорилготой дугуйлан, секц, уулзалт, өдөрлөгийн арга хэмжээг тогтмолжуулна.

1.4.4 Хөдөөгийн иргэдэд урлаг, соёл, спортын арга хэмжээг жил, улиралд тогтмол хүргэх хөтөлбөр, төлөвлөгөө, график хуваарь боловсруулж сумын ИТХ-аар батлуулж мөрдөж ажиллана.

Хоёр. Эдийн засгийн хөгжлийг тогтвортой хангах бодлого



000000000003

2.1 Хөдөлмөр эрхлэлт, шинэ ажлын байр, бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл.

2.1.1 Загзуугийн амны ногоочдыг түшиглэн усалгаатай төмс, хүнсний ногоо тариалах бага оврын усалгааны тоног төхөөрөмж суурилуулах. Шинээр төмс, хүнсний ногоо тариалахыг хүссэн иргэдэд газар олгох, өргөтгөх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн хөрөнгө санхүүгийн дэмжлэгт хамруулах замаар бүх талаар дэмжинэ.

2.1.2 Шинэ ажлын байр буй болгох чиглэлээр сумын төвд доорх арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Үүнд:

- Сумын өвсний фондын хашааг түшиглэн өвлийн хүлэмж байгуулж, тэнд ажиллахыг хүссэн иргэдийг “Иргэдийн нөхөрлөл-ийн зохион байгуулалтанд оруулж ажиллуулах, ажиллах хүмүүсийг мэргэшүүлэх сургалтанд хамруулж сургаж бэлтгэх.
- Сумын төвд төмс, хүнсний ногоо хадгалах зоорийг аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө санхүүгийн дэмжлэгтэйгээр бариулж ашиглалтанд оруулах.
- Ахуйн үйлчилгээний төвийн барилгад их засвар, үйлчилгээ хийж, оёдол, эсгүүр, хувцас засвар, гутал засвар, гар утас компьютер засвар, дарханы болон цахилгаан хэрэгслэлийн засвар, гэрэл зураг гэх мэт үйлчилгээг явуулах боломж нөхцлийг бүрдүүлэх.
- Өрхийн үйлдвэрлэл эрхэлж ажлын шинэ байр буй болгохыг хүссэн иргэдэд мужаан, дарханы багаж, сүү, цагаан идээ, талх, нарийн боов хийх тоног төхөөрөмж зэрэг ажлын багаж хэрэгслэлийн дэмжлэгийг төсөл хөтөлбөрийн дэмжлэгт хамруулж ажиллах.
- Сумын төвд жилийн 4 улиралд байнга оршин суудаг өрх, иргэдийг Баян хошуу багийн харъяат болгох арга хэмжээг иргэний бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх.
- Сумын төвийн хөгжил байршилийн 2021 хүртэлх ерөнхий схемийг 2035 он хүртэл хугацаанд баримтлах баримт бичиг болгож сумын ИТХ-ын хуралдаанаар шинэчлэн батлаж мөрдөх

2.1.3 Бүрэнхаан, Эрчим багт малын ногоон тэжээл тариалахыг хүссэн хоршоо, малчдын нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж жижиг оврын трактор, бусад төрлийн тоног төхөөрөмжөөр хангах талаар зохих дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, төсөл хөтөлбөрт хамруулах талаар уламжилж ажиллана.

2.2 Эрчим хүч, зам тээвэр, ложистик:

2.2.1 Сумын төвийн газрын хөрсийг эвдрэлээс хамгаалах зорилгоор сумын төвийн авто машины төв болон туслах замуудыг сумын төсвийн хөрөнгө санхүүгийн боломж, иргэдийн үүсгэл санаачлагад тулгуурлан хатуу хучилттай болгох, аймгийн төсөвт тусгах арга хэмжээ авч ажиллах.

2.2.2 Мөрөн-Бүрэнтогтох хооронд 35 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам шинээр татуулах, сумын төвийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн цахилгаан эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг улс, аймгийн төсөвт тусгуулах зорилт тавьж хэрэгжүүлнэ.

2.2.3 Боом, Загзуу, Дулаан, Бүлээн зэрэг орон нутгийн зам давааг ОНХС-ийн хөрөнгө, санхүүжилт, иргэдийн хүч оролцоотойгоор жил бүр засварлана.

2.3 Дөрвөн улирлын аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл:

2.3.1 Дулаан, Хядгын рашаан, Дэлгэрмөрөн голын зарим ай сав газрыг түшиглэн дотоодын аялал жуулчлал, амралт сувилалыг хөгжүүлэх маршрут бий болгож, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллах, дэмжих.

2.3.2 Туяа багийн нутаг дахь Уушгийн өврийн буган чулуун хөшөөний орчмыг түшиглэсэн түүх, соёлын болон нүүдэлчдийн аж амьдралыг сурталчлах зорилготой аялал, жуулчлалын маршрут, сүлжээ бий болгоно.

2.3.3 Малчин өрхийн аялал жуулчлалыг дэмжиж гадаад дотоодын жуулчин хүлээн авч өөртөө ажлын байр гаргах нөхцөл боломж бүрдүүлэх.

2.4 Эрүүл хүнс:

2.4.1 Бүрэнхаан багт сүү, цагаан идээ боловсруулах жижиг үйлдвэр цех байгуулж ашиглалтанд оруулах

2.4.2 Бяслалгны үйлдвэрийг малчдын хоршоо буюу олон үхэртэй малчдын нөхөрлөлд хариуцуулан өгч үйл ажиллагааг тогтмолжуулах. Энэ ажилд сумын Засаг даргын тамгын газрын ХАА-н тасгийн зүгээс тавих тусламж дэмжлэг, зөвлөмж, зөвлөгөө, хяналтыг эрс сайжруулах. Сүү зөөх зориулалтын авто машин худалдан авахыг дэмжинэ.

2.5 Хөдөө аж ахуй, шинэ хоршоо хөдөлгөөн:

2.5.1 Шинэ хоршоо хөдөлгөөнийг дэмжих, тэргүүний ажиллагаатай зарим хоршооны туршлагыг нийтийн хүртээл болгон үзүүлэх сургууль, туршлага солилцох уулзалт, сургалтыг хоршооны дарга, удирдлага, гишүүдийг оролцуулан зохион байгуулна.

2.5.2 Шинээр хоршоо байгуулахыг хүссэн малчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, хоршооны дүрэм, журам боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх зэрэгээр тусална.

2.6 Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт уул уурхай:



2.6.1 Дэлгэрмөрөн голын ай сав дагуу элс хайрга ашиглахаар олгосон зөвшөөрлүүдэд дахин хяналт тавьж, зарим зөвшөөрлийг цуцлах, нөхөн сэргээлгэх зэрэг арга хэмжээ авч ажиллана.

2.6.2 Бүрэнхааны фосфоритын ордыг ашиглуулахгүй байх бодлогыг сумын зүгээс хатуу баримтлана.

2.6.3 Сумын нутаг дэвсгэрт шинээр ашиглалтын болон хайгуулын лиценз олгохыг дэмжихгүй.

Гурав. Шударга иргэдийн оролцоонд тулгуурласан цахим засаглал

3.1 Хүний эрх:

3.1.1 Хувь хүн, гэр бүлтэй ажиллах талаар нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн ажиллах орчин нөхцөлд онцгой анхаарч, хүлээх үүрэг хариуцлагыг сайжруулна .

3.1.2 Гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих хандлагыг өрх, иргэдийн дунд бий болгож, нөлөөллийн арга хэмжээг сайжруулна.

3.1.3 Ганц бие болон өрх толгойлсон эцэг, эхийн ахуй амьдралын асуудалд онцгой анхаарч төрийн зүгээс үзүүлэх тусламж, дэмжлэгийн асуудлыг шуурхай шийдвэрлэнэ.

3.1.4 Малчдын мал сүрэг, иргэдийн орон сууц, эд хөрөнгийг хулгай дээрэм, гадны халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, гэмт үйлдлийн мөрөөр шуурхай ажиллаж хэрэг үйлдсэн этгээдийг цаг алдалгүй илрүүлэхэд цагдаа, хэсгийн төлөөлөгч нарын ажлын шуурхай байдлыг эрс сайжруулна.

3.1.5 Хүүхэд хамгааллын талаарх иргэдийн мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлж, хүүхдийг элдэв эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд сургууль эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулна.

3.2 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа:

3.2.1 Сумын хэмжээнд дутагдалтай байгаа багийн хүний эмч, малын эмч, сувилагч, зарим мэргэжлийн багш нарыг сумын гэрээгээр шинээр сургаж бэлтгэх, давтан сургах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр бодлого боловсруулж ажиллана

3.2.2 Шинээр сургууль төгсөж ирсэн залуу боловсон хүчнүүдийг орон сууцаар хангах, хоол хүнс, түлш түлээний дэмжлэг үзүүлэх талаар сумын

Хурал, Засаг дарга, төсөвт байгууллагын дарга, захирал, эрхэлэгч нарын хөтөлбөр, эрхэм зорилтод зориуд тусгаж хэрэгжүүлнэ.

3.2.3 Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэжлийн мэргэшсэн жинхэнэ албан хаагчдаар бүрдүүлж төрийн үйлчилгээний чанарыг эрс сайжруулан тэднийг мэргэшүүлэх, давтан сургах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, тогтвор сууршилтай ажиллуулна.

3.3 И Монголий шинэчлэл, цахим засаглал:

3.3.1 Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, газрын бүртгэл харилцаанд “блокчейн” технологийг ашиглах, иргэдэд цахим технологи ашиглах арга ажиллагааг сургахад төрийн байгууллагын ажилтнуудын ажлыг чиглүүлж цахим засаглалыг хэрэгжүүлнэ.

3.3.2 Төрийн хууль тогтоомж, Засгийн газар, аймаг, сумын Хурал, Засаг даргын үйл ажиллаганы хөтөлбөр, гаргасан бодлого шийдвэрийг сумын Хурал, засаг даргын тамгын газрын цахим хуудас, сумын цахим хаягаар иргэдэд өргөнөөр сурталчлах, чанар хүртээмж, арга хэлбэрийг боловсронгуй болгох, цахим засаглал, мэдээлэл түгээлтийг цахимаар түргэн шуурхай нийтэд хүргэдэг байхад анхаарч ажиллана.

3.3.3 Сумын хэмжээнд төрийн болон хувийн хэвшилд ажлын байрны орон тоо гарсан тохиолдолд ажлын байрыг тухай бүр нээлттэй зарлаж шилэн байдлаар сонгон шалгаруулах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

3.4 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ:


3.4.1 Төрийн албыг чадварлаг болгох, тэдний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулж, үйлчлүүлэгч иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

3.4.2 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харъяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

3.4.3 Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог сайжруулж урамшуулал болон арга хэмжээг бодитойгоор тооцно.

3.4.4 Төрийн албан хаагчдыг мэргэшсэн, чадварлаг, үйлчилгээний өндөр харилцаатай байхыг шаардах ба иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж хариуг холбогдох эздэд хүргэдэг байх тогтолцооны гүйцэтгэлд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллана.

Дөрөв. Хүн ба хүрээлэн буй орчин



A red rectangular official stamp is located at the bottom right of the page. The stamp contains vertical text in Mongolian script. Below the stamp is a handwritten signature in black ink. To the right of the signature, the number '0000000005' is printed in blue.

4.1 Уламжлалт нүүдлийн аж ахуй ба сорилт бэрхшээл:

4.1.1 Сумын бэлчээр нутгийг жилийн 4 улиралд зохистой ашиглах журмыг шинэчлэн боловсруулж багийн ИНХ-аар хэлэлцүүлэн сумын ИТХ-аар батлуулж мөрдөнө.

4.1.2 Бэлчээрийг усжуулах зорилгоор зарим газар нутагт гүн өрмийн худаг шинээр гаргуулж, ашиглалтгүй зарим худаг, уст цэгүүдэд засвар үйлчилгээ хийж ашиглана.

4.1.3 Малын бэлчээрт хөнөөл учруулж байгаа царцааны нүүдэл, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх ажлыг малчдын оролцоонд тулгуурлан үр дүнг сайжруулна.

4.1.4 Газар эзэмшигч, ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, хөрсний эвдрэл доройтолд орсон газрыг нөхөн сэргээх, өнжөөх зэрэгээр хөрсний доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.

4.1.5.Бэлчээрийн доройтлыг бууруулах үүднээс малын үүлдэр угсаа, чанарыг сайжруулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх замаар малын тоо толгойг багасгах, өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх санал санаачлагыг малчид, мал бүхий иргэдэд сурталчилж, хамтран ажиллана.

4.1.6 Уламжлалт нүүдлийн соёлыг хадгалах, түгээн дэлгэрүүлэх, шинэ санаачлагыг урамшуулан дэмжих,түүх соёлыг өвлүүлэн тээхэд анхаарч залуу үеийг халамжлан хүмүүжүүлж хөдөөг харах эзэн, хамгаалах малчны тоог нэмэгдүүлнэ.

4.2 Ногоон эдийн засаг:

4.2.1 Хогийн нэгдсэн цэгийн хог хаягдлыг цэвэрлэж хашаажуулах, хог булшлах нүхийг өргөтгөх, хог асгасан тайлбайн хэмжээг багасгах зэрэг арга хэмжээг жил бүр зохион байгуулж ажиллана.

4.2.2 Хог ангилан ялгах, хоёрдогч түүхий эд ашиглах талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийг дэмжин хог хаягдлыг ангилан ялгах сайн туршлага, санаачлагыг бүх талаар дэмжинэ.

4.2.3 Үхсэн малын сэг зэмийг замбараагүй хаяж байгаль орчныг бохирдуулдаг явдлыг таслан зогсоож, баг бүрт малын сэг зэмийг хаяж устгах газрыг Сумын Засаг даргын захирамжаар тогтоож өгч мөрдүүлнэ.

Тав. Хот хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлого

5.1 Хойт бүсийн хөгжил:


5.1.1 Бичил бизнес эрхлэхийг хүссэн тус сумын хувиараа эрхлэх аж ахуйн нэгж, өрх иргэдийг Эрдэнэт хотын энэ чиглэлээр ажилладаг бичил бизнес эрхлэгчидтэй холбож үйл ажиллагааг эхлүүлнэ.

5.1.2 Мөрөн-Бүрэнтогтох сумыг холбосон засмал зам барих саналыг аймгийн Засаг даргаар уламжлан УИХ, Засгийн газарт хүсэлт болгож тавина.

5.1.3 Мал аж ахуйн албан татварын орлогыг тухайн багийн хадлан тэжээл бэлтгэх нөөц бүрдүүлэх, булаг шанд хашиж хамгаалах, худаг уст цэгийг нэмэгдүүлэх, засвар үйлчилгээг хийлгэх буюу малчдад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна.

5.2 Бүрэнтогтох сумын хөгжлийн төлөвлөлт:

Бүрэнтогтох сумын хөгжил 2024-2028 онд ажлын байр нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл бий болж сумын брэнд бүтээгдэхүүнтэй, малчин, малчны хоршооны үйл ажиллагаа тогтмолжиж, дотооддоо болон хөрш Мөрөн сумыг малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдээр хангаж сумын төвийн тохижилт, соёлжилт, зам харилцаа, холбоо, төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагаа, үйлчилгээний соёлыг энэхүү мөрийн хөтөлбөрөөр сайжруулна.



**БҮРЭНТОГТОХ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**



0000000006

